



Ардчилсан намын даргад нэр дэвшигч

Н.АЛТАНХУЯГ

хандивын данс
ХААН БАНК 5128020709

Дугаарын 60 мөр

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

Цахим картгүй бол автобусанд зорчуулахгүй байя

Н.ПУНЦАГБОЛД

Автобусны мөнгөний хайрцганд хийсэн тал 500, 1000 төгрөгийн зураг саяхан фэйсбүүкээр баахан тарж, сэдэв боллоо. Бас нэг нөхөр өөрийн цахим хуудсандаа “Нэг танил маань 500 төгрөг дундуур нь ураад байхаар нь асуусан чинь хоёр удаа автобусанд суудаг юм” гэж хариулсан талаар бичээд байсан. Монголчуудын тодорхой хэсгийн сэтгэлгээ нэг иймэрхүү л байна шүү дээ. Иймэрхүү ч гэж дээ, ядуу, ухамсар дорой, ухаан муутай гэсэн үг. Хариуцлага хүлээж сураагүй, улс орноо боддоггүй, зүгээр л бэлэнчилж суух хүсэлтэй хүмүүс нэмэгдсээр байгаагийн илрэл.

Б.ДАВАА

Нийслэлийн зах хэсэг дэх гэр хорооллын дунд оройдоо загалмай хадсан сүмийн барилга энд тэндгүй таарах бөгөөд сүүлийн жилүүдэд тоо нь ч улам олширсоор байх ажээ. Харин уламжлалт шашин гэгддэг буддын шашны хийд хотын зах хэсэгт тоотойхон таарах авч, нийслэлийн төв хэсэгт шигүү байрлаж, сүсэгтэн олны засал номыг айлдсаар ирсэн байх юм. Гэхдээ том модон хаалганы цаана орших хийд, гаднаа загалмай хатгасан Христийн сүм дотор юу өрнөдөг нь тодорхой бус. Тиймээс “Монголын мэдээ” сонин энэ удаа Христийн сүм хийгээд Буддын хийдэд өрнөдөг “хаалганы цаана орших нэгэн ертөнц”-д зочлон дугаарын сурвалжлагаа бэлтгэлээ. Гэхдээ 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу шашин шүтэх эс шүтэх нь тухайн хувь хүний бүрэн эрх учраас хэний ч итгэл үнэмшил, шашин шүтлэгийг үгүйсгэх гэсэнгүй.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Үргэлжлэл нь III нүүрт

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

ЗАЛУУСЫН ХОТХОН

X Apartment



АВАРГА, АРСЛАНТАЙГАА ХИЙМОРЬТОЙ АМЬДРАХ БОЛОМЖ





























24 цагийн харуул хамгаалалт, хүлээн авах ресепшн

C, D блокын төв орцтой холбогдох хэсэг

Дулаан авто зогсоолтой

Таны мөнхийн залуу гоо сайханд зориулан мэргэжлийн салон

Таны хүүхдэд зориулсан монтеessori сургалттай цэцэрлэг

Таны гэр бүл найз нөхөдтэйгээ хамт байхад зориулан Кофе шоп

Таны урлагын мэдрэмжинд зориулсан уран зургийн галерей

Таны төмөр хүлэгт зориулсан Авто угаалга

TDB

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ХААН БАНК

ТӨРИЙН БАНК

ГОЛОМТ БАНК

ХАСВАНК

- ЗГ-аас харэгжүүлж буй 8% зээлээ 7 хоногт шийдвэрлүүлэх:

Та 100% ашиглалтанд орсон орон сууцнаас сонголтоо хийж, бидэнтэй хамтран ажилладаг банкуудаар тусгайлан үйлчлүүлж 8% зээлээ 7 хоногийн дотор шуурхай шийдвэрлүүлэх таатай боломжийг санал болгож байна.

- Албан байгууллага, хамт олноороо сонголт хийснээр эдлэх тусгай хөнгөлөлт:

Хамт олноороо орон сууцнаас сонголт хийж үнийн хөнгөлөлт, авто зогсоолын хөнгөлөлт, цэцэрлэгт хүүхдээ үнэгүй суралцуулах эрх зэрэг таны тав тухтай амьдрахад чиглэсэн бодит хөнгөлөлтүүдийг санал болгож байна.

- Бизнесмен танд зориулсан уян хатан нөхцөл:

Та өөртөө болон хамт олондоо зориулан манай орон сууцнаас сонголт хийж, барилгын сайн чанарын материалууд болон арматураар харилцан ашигтай хамтран ажиллах боломж бүхий таатай нөхцлийг санал болгож байна

- Банкны хүүгүйгээр өөрийн болгох боломж:

Амжилтай яваа бизнесмен та өөрийн таалалд нийцсэн орон сууцыг бидний нэрлэсэн үнээр худалдан авч, төлбөрийн 50 хувийг төлөөр үлдэгдэл төлбөрөө 1-2 жилийн дотор хүүгүйгээр төлөх төлбөрийн нөхцлийг онцгойлон санал болгож байна.

ОРШИН СУУГЧДЫНХАА ТАВ ТУХ, ЭРҮҮЛ БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭЖ ДЭЛХИЙД ЧАНАРААР ТЭРГҮҮЛЭГЧ БРЭНДҮҮДЭЭР “Х АР АРТМЕНТ”-ЫГ ТОНОГЛОЛОО

VEKA

ГЕРМАН ВАКУМ ЦОНХ

TOTO

ЯПОН САЙГИЙН ТОНОГЛОЛ

LG Hausys

СОЛОНГОС ОБОЙ

NIPPON PAINT

ЯПОН БУДАГ, ЭМУЛЬС

E EGGER

АВСТРИ ПАРКЕТАН ШАЛ

ThyssenKrupp

ГЕРМАН ЦАХИЛГААН ШАТ

AQUATHERM

ГЕРМАН ХОЛБОХ ХЭРЭГСЭЛ

MEGAWOOD

MEGAWOOD ХААЛГА

Х-Апартментын хаяг: Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордоны зүүн урд талд

Захиалга авах хаяг: Сүхбаатар дүүрэг Улсын драмын театрын хойд талд “УЛААНБААТАР ПРОПЕРТИЗ” ХХК өөрийн байранд

www.xapartment.mn

www.ubproperties.mn

УТАС: 88002312, 88030203

УТАС: 96066329, 77009919

ХААН банк					Худалгаа хөгжлийн банк					
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2484.00	2494.00	ФУНТ	3027.00	3131.00	АМ.ДОЛЛАР	2480.00	2494.00	ФУНТ	3044.00
ЕВРО	2551.00	2621.00	РУБЛЬ	38.50	41.80	ЕВРО	2554.00	2636.00	РУБЛЬ	39.17
ИЕН	20.98	21.30	ЮАНЬ	356.90	360.00	ИЕН	20.96	21.62	ЮАНЬ	356.50

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

E-mail: mongoliin_medee@yahoo.com

Реклам, зар сурталчилгааны алба: 99173710

ҮЗЭЛ БОДОЛ



Н.ПУНЦАГБОЛЦ

Эхлээд жаахан тоо дурьдая. Сүүлийн 3-4 жилийн дотор манай улс “Үнэ тогтворжуулах” хөтөлбөрийн хүрээнд 4.0 их наяд төгрөгийн хөнгөлттэй зээл, Хөгжлийн банк, “Чингис” болон “Самурай” бонд зэрэг эх үүсвэрээс 7.0 их наяд төгрөгийн хөрөнгө зарцуулсан. 2015 оны эхний хагас жилийн байдлаар улсын гадаад өр 21.7 тэрбум ам.долларт хүрсэн гэсэн тоо бий. Энэ талаар эдийн засагчид тоо баримттай нь ярьж байгаа. Мэдээж энэ өрийг Засгийн газрын болон дотоодын компаниудын гэж ялгаж, зааглах л ёстой байх. Гэхдээ л манай улсын өр мөн үү гэвэл тийм. Ер нь манай улс өнгөрсөн жилээс эхлээд гадаад өрөө төлж л яваа. 2015 онд 500 тэрбумыг төлсөн бол энэ жил нэг их найдыг гаргасан. Гэхдээ 2017 оноос төлж эхлэх их өрөнд бүгд анхаарал хандуулж, ач холбогдол өгч яриад байна. Ерөөс Сангийн сайд Б.Чойжилсүрэнгийн ажлаа авсныхаа дараа мэдээлсэн мэдээллээс үзвэл 2017 онд манай улс 1.6 их наяд төгрөгийг гадаад өрөнд төлөхөөр байгаа. Энэ бол манай улсын төсвийн 20-нод хувь гэсэн үг. Үнэхээр их мөнгө. Тийм учраас эдийн засагчид, улстөрчид санаа зовоод, ач холбогдол өгөөд яриад байгаа болов уу. Ядаж байхад зээлсэн мөнгөө хэрхэн төлөх талаар нарийн төлөвлөгөө манайд байхгүй. За яахав, ямар ч байсан төлнө дөө л гэж яриад явж байгаа. Хүнээр бол нэг хэнэггүй нэг нөхөр юм уу даа. Дээрээс нь Монгол Улсын эдийн засаг элгээрээ мөлхчихлөө. Өөдтэй өнгөтэй тоо, гэрэл гэгээтэй мэдээ алга. Эдийн засаг сэргэнэ гэж найдахад тун хэцүү. Эрх баригчид ч 2018 оны тухай л яриад байгаа. 2018 онд эдийн засаг өөдөлнө, гайгүй болно гээд л. Гэтэл дунд нь 2017 он гэж байна. Ирэх онд манай улсын эдийн засагт нэг их гэрэл харагдахгүй л байгаа. ОУВС-гаас манай улсын эдийн засгийн өсөлтийг 2.5 хувь байхаар төсөөлсөн. Яг энэ төсөөллөөр өснө гэвэл өсөлт гэж мэдрэгдэхгүй л болов уу. Дээрээс нь энэ магадгүй жаахан өөдрөг ч төсөөлөл байж болно. Ядаж байхад манай төлбөрийн тэнцэл алдагдалтай гарсаар байгаа. Аравдугаар сарын тоон мэдээллээр төлбөрийн тэнцэл -277 сая ам.доллар байна. Мөн манай зээлжих зэрэглэлээс авахуулаад буугаагүй юм гэж алга. Гадаадын шууд хөрөнгө оруулалт бараг л байхгүй болчихлоо. Ийм байхад манайх

өрөө төлж барах уу. Дотоодын нөөц боломжоор өр төлнө гэж байхгүй. Үүнийг л дурьдах гэж дээр баахан тоо баримт бичээд яншаад байсан хэрэг. Гэтэл өр төлөх хугацаа юу юугүй хаяанд ирлээ. Өнөө их өр шүү дээ. Одоо 10 гаруйхан хоногийн дараа 2017 онтой золгох гэж байна. Манай улсад нэг их баярлаж хөөрцөглөөд байх юм алга. Өрөө төлж чадахгүй бол яах билээ. Үндсэндээ улс орон дампуурна гэсэн үг. Өрөнд нэрвэгдсэнээ зарлана. Улсын өр надад ямар хамаа байх вэ гэж манайхан бодоод байх шиг байгаа юм. Үгүй шүү дээ. Нарийндаа бол хүн бүхний нуруун дээр бууна. Улс мөнгөө өрөө төлөхөд зарцуулж, нийгмийн халамж, хамгаалал, цалин хөлс гээд бүх орлого хумигдана. Төсөл, тендерүүд цуцлагдаж, ажлын байрууд алга болно. Муу ёр ч байгаа даа, гэхдээ л бид ийм дээрээ тулахад ердөө хөдхөн алхам л үлдчихээд байгаа. Хүнээр бол сэхээнд байна. Гэтэл эрх баригчид өр төлөх тал дээр ярьж, хийж байгаа ажил байна уу гэж бодогдохоор л байна. ОУВС-гаас зээл авна гээд байгаа. Уг нь манайд ирээд, нөхцөл байдлыг хараад, судлаад, бүр зээл өгөх эсэхээ шийдчихээд явсан гэсэн мэдээлэл гарсан л даа. Гэхдээ яг бүтэх юм уу, бүтлээ гэхэд хэдийг өгөх юм. Эхний

ээлжинд гал унтрааж хүрэх юм уу гээд бачимдах зүйл их байна. Уг нь Хятадаас овоо зээл аваад, асуудлаа шийдэх гээд байх шиг байсан. Гэвч Далай ламын айлчлалтай холбоотойгоор бөөн асуудал үүсчихлээ. Зээл бүтэхээ болилоо л гээд байх юм. Зарим нь болохоор Хятадтай асуудал шийдэхээр тохирчихсон, Далай лам зүгээр л жүжиг гээд байгаа. Яг үнэндээ Засгийн газраас гэрэл гэгээтэй мэдээ дуулдаагүй л байгаа шүү дээ. УИХ-ын дарга баахан гишүү дагуулаад л Орос руу давхисан. Янз бүрийн л асуудал ярьж, хурал хуйд оролцоод яваа бололтой. Бүр зарим нэг хүмүүсээс зэмлэлийн үг хүртэл дуулсан шиг явж байгаа. Тэгэхдээ өр ширээ төлөх асуудал шийдэх талаар яриа гарч байгаа юм уу, бүү мэд. Одоохондоо бол Монгол Улс яг тэгээд өрөө дарна, шийдчихнэ гэсэн юм алга. Өөр арай бага хүүтэй, урт хугацаатай мөнгө зээлж, түүгээрээ өрөө дарах гарц байгаа талаар эдийн засагчид ярьсаар л. Гэтэл бидэнд тийм мөнгө зээлэх улс, хөрөнгө оруулагч байгаа бил үү. Ядаж барьцаанд тавиад мөнгө зээлчих томоохон орд юу билээ. Оюутолгой, Тавантолгой бол аль хэдийнэ үлгэр болсон. Монгол улс ломбарданд тавьчих эд хогшил ч байхгүй айл шиг л байна.

Өрөө яаж төлөх вэ, гарц байна уу. ОУВС-гийн зээл бүтнэ л гэж хүлээхээс өөр аргагүй л байдалд энэ төр засгийнхан шилжчих шиг боллоо. Тэгж л хардаад байна. Түүнээс биш асуудлыг нааштай шийдчихсэн бол өдийд хэлж яриад, мэдээлмээр юм. Эсвэл он гаргаж байгаад хийж буй ажил, хэрэгжүүлж байгаа хөтөлбөрөө танилцуулах юм болов уу. Одоохондоо бол нэг л их гадаад руу бөөн бөөнөөрөө явсан, хотынхон нь янз бүрийн баяр тэмдэглэж, гацуурын гэрэл асаалаа гэж тоглолт хийж, мөнгө цацсан л хүмүүс байна. Огт хямраагүй, өр ширэнд баригдаагүй юм шиг л байгаа. Хурал хуйдаа суудаг гишүүн ч гэж байхаа болилоо. Ирэх онд тийм ч ажил хийнэ, ингэж ч зам засна, тийм бүтээн байгуулалт хийнэ гэж яриад л. Тэр мөнгө нь хаана ч байгаа юм. Хэрвээ ОУВС-гийн зээлийг найдаж хүлээж байгаа бол жижигхэн мөчрөөс атгаад уерт урсахгүй гэж хичээж байгаагаас ялгаа байна уу. Хэрвээ зээл бүтэхгүй болчихвол яах вэ. Дахиад л улс дампуурах асуудал яригдана. Ёстой гэнэтхэн том төсөл хөтөлбөрүүд нь хөтлөөд, гэнэт л эдийн засаг дэлбэ дээшилж, баяжчихдаггүй л юм бол одоохондоо гэрэлтэй юм бодоход хэцүүхэн л байна даа. Тэд гадаад өрөө яаж төлөх гэж байгаа юм бол.

Дугаарын 60 мөр

Цахим картгүй бол автобусанд зорчуулахгүй байя

Үргэлжлэл. Түүрүүч нь I нүүрт

Автобус ухаалаг системтэй болсноор алдагдалтай ажиллахаа больсон байх. Тасалбар түгээгч гээд олон хүн ажиллахаа больсон. Дээрээс нь тасалбар түгээгч, жолооч нь өдрийн орлогоосоо “хумсалдаг” байсан цаг ард хоцроод байгаа. Тийм болохоор өмнөхөө бодвол орлогоо бүтнээр шахуу аваад, дээрээс нь тасалбар түгээгчийн цалингийн цэс хасагдсан. Ухаалаг системийн ач тус энэ. Гэхдээ увайгүй, ухамсаргүй зарим нь мөнгөө урж хийгээд байвал бас хэцүү шүү дээ. Тиймээс ямар нэг арга хэмжээ авах хэрэгтэй юм биш үү. Хяналтаа сайжруулах, цаашлаад бүх иргэдийг автобусны карттай байхыг шаардмаар байна. Уг нь картаар бол 500 төгрөг, мөнгө хийвэл 1000 гэсэн журам маягийн юм гаргасан. Бүх хүмүүсийг карттай болгох гэж тэр шүү дээ. Гэтэл хэрэгжсэн ч юм алга, иргэд ч тоосонгүй. Хэрэгжүүлэхээр шахаж шаардсан ч үгүй. Нэг үеэ бодвол иргэдийн цөөнгүй хувь нь автобусны карттай болчихсон. Гэхдээ л бүх нийтээрээ картаа хэрэглэж сураагүй хэвээрээ л байна. Тиймээс хатуухан үзэж, цахим картгүй бол автобусанд суулгахгүй байвал яасан юм. Ингээд хэлэхээр хүний эрхийн асуудал гэж ирээд л хэл амаа билүүдэх нөхөд цөөнгүй гарч ирэх байх. Гэхдээ аль болгон ард түмэн уурлана гэж алгын чинээ болж байдаг юм. Зарим зүйл дээр жаахан зарчмтай, хуультай, дүрэмтэй байм л даа, энэ чинь. Ямар мөнгийг нь дээрэмдэх гэж байгаа биш, автобусны цахим карттай л бол гэж шаардах гэж байна. Тэгээд ч цахим карт гэдэг давуу талтай. 5000 төгрөгөөр цэнэглэхсэн байхад өөр юманд мөнгөө үрчихнэ гэхгүй амар. Байж л байна. Ганц нэг дамжих зэрэгт бол мөнгө үрэхгүй. Дамжин суулт үнэгүй болчихсон. Мөнгөтэй ноцолдоод, түрүүвчээ ухаад байхгүй. Гэх мэтээр ухаалаг системийн давуу тал зөндөө л байна. Дээрээс нь автобус компаниуд уранхай мөнгөтэй зууралдаад байхааргүй болно. Ийм л байгаа юм. Тиймээс долоо хоног хэдэн шалгагч гаргаад, картгүй бол суулгахгүй гээд жаахан “төмөр нүүрэлчих”. Яахав, нэг удаадаа явуулъя, маргаашнаас тийм юм байхгүй гээд л зад загнаад байвал манайхан эхэндээ жаахан шөвөгнөх л байх, тэгээд ганц хоёр хоногоос картаа аваад, автобусандаа зорчоод л явчихна шүү дээ. Хамгийн гол нь аливаа дүрэм журмыг мөрдүүлж хэвшүүлэх тал дээр л эхний ээлжинд жаахан хүчин чармайлт гаргачихмаар байгаа юм. Тэгж чадвал монголчууд хуулиа дагадгүй, мөрддөггүй хүмүүс ч бас биш. Дээрээс нь хөнгөлөлттэй зорчигчийн үнэмлэх барьчихсан баахан хүн Улаанбаатарт байгаа. Тэд картаа дарж л автобусанд зорчих ёстой. Гэтэл дарахгүй тохиолдол маш их байна. Жолооч нь хэд хашгираад аргаа барна, өнөөдүүл чихгүй толгой аятай хойшоо зүтгээд, арай залуу харагдсан нэгний сандлыг дээрэмдээд суучихна. Бүр болохгүй жолооч руу уурлаж, “Сүртэй юм, дарах алба ч байхгүй” гэж хэдэрлээд явж байгаа. Энэ мэтийг жаахан дүрмэнд нь оруулж, иргэдийн ухамсар сэтгэхүйд нөлөөлмөөр байна аа.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Гэрэл зургийн Г.АРТУУЖИН

ДЭЛХИЙ

ОХУ-ЫН ТУРК ДАХЬ ЭЛЧИН САЙД АМИА АЛДЛАА

Б.ДАВААХҮҮ

ОХУ-аас Туркид суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Анкара хотод нээгдсэн уран зургийн үзэсгэлэнд оролцох үедээ цагдаагийн ажилтанд буудуулж амь үрэгдсэн хэрэг дэлхий дахинаа өрнөсөн онцлох үйл явдлын нэг байв. ОХУ-ын Элчин сайд Андрей Карлов Туркийн нийслэлд болсон уран зургийн үзэсгэлэнд оролцож, үг хэлэх үед нь гэмт этгээд араас нь буудан амийг нь бүрэлгэжээ. Энэ үеэр гурван хүн мөн гэмтэж бэртсэн гэх мэдээлэл байгаа юм. Андрей Карлов агсныг микрофоны өмнө гарч, ердөө хэдхэн минут үг хэлж байхад нь костюм өмсч, зангиа зүүсэн этгээд гэнэт “Аллах Акбар” хэмээн хашгирч, найман удаа гал нээжээ. Хэргийн үйл явцыг харуулсан видео бичлэг ч өчигдөр цахим сайтуудад нийтлэгдсэн байв. Гэмт этгээд “Бид Алеппод үхэж байна. Харин чи энд үх”, “Алеппог мартаж болохгүй, Сирийг битгий мартаарай” хэмээгээд “Хойшоо болцгоо, хойшоо болцгоо. Зөвхөн үхэл л намайг эндээс авах болно. Намайг эсэргүүцсэн хэнийг ч хөнөөх болно” гэх зэрэг үгсийг урсгаж байсныг гэрчүүд мэдэлж байгаа аж. Залуугийн хэлсэн “Аллах Акбар” гэх үг нь араб хэлээр “Аллах хамгийн агуу” гэх утгийг илэрхийлдэг байна. Мөн зарим эх сурвалж, гэмт этгээдийг араб хэлээр “Бид бол зөнч Мухаммадын үр удам” хэмээн хашгирсан хэмээн мэдэлж байв. Харин түүнийг ийн байхад Туркийн нэгэн цагдаа буудан хөнөөжээ. Сирийн арми Алеппо хотыг хэт даврагчдаас чөлөөлөх тэмцлийг эхлүүлж, ОХУ-ын цэргийнхэн агаараас дэмжлэг үзүүлж буй. Энэ үеэр олон энгийн иргэний амь үрэгдэж байгааг хүний эрхийн байгууллагаас удаа дараа мэдэлж байгаа билээ. Ямартай ч, хэрэг гарсны дараа ОХУ ямар хариу үйлдэл үзүүлэх нь олон улсын анхаарлын төвд байлаа. Харин тус улс хэргийг “Террорист халдлага” гэж үзэж буйгаа тус улсын Гадаад хэргийн яамнаас мэдэгдсэн байна. Ерөнхийдөө Туркид 1990-2010 оныг хүртэл Турк дахь халдлагын гаралт тодорхой хэмжээнд



буурсан ч, 2010 оноос хойш тасралтгүй өссөн үзүүлэлтэй болж ирсэн байна. Цэргийн эргэлт хийх оролдлого гарсантай холбоотойгоор онц байдал зарласан тус улсын Истанбул хотод саяхан гэхэд цуврал дэлбэрэлт болж үй олон хүн нас барж, гэмтэж бэртсэн юм. Тэгвэл ОХУ-ын Гадаад хэргийн

яамны төлөөлөгч Мария Захарова “Өнөөдөр Анкараг онилсон террорист халдлагын улмаас Туркид суух ОХУ-ын Элчин сайд Андрей Карлов амиа алдлаа. Бид террорист ажиллагаа гэж үзэж байна” хэмээн мэдэгджээ. Харин Анкара хотын захирагч ОХУ-Туркийн харилцааг зориуд хурцатгах гэсэн

зорилготой халдлага байж магадгүй гэж үзжээ. Өмнө нь Сирийн хилийн орчимд нисч явсан ОХУ-ын байлдааны онгоцыг Туркийн тал буудаж унагасан хэрэг хоёр улсын харилцаанд гал авалцуулж байсан удаатай.

Элчин сайдыг буудсан этгээд цагдаагийн ажилтан байжээ

Оросын элчин сайдыг буудан амийг нь хороосон этгээд Туркийн цагдаагийн шуурхай хариу арга хэмжээ авах хэсгийн албан хаагч байжээ. Тэрээр 22 настай байсан бөгөөд Туркийн баруун хэсгийн Айдин гэх тосгонд төрсөн, Анкара хотын цагдаагийн газарт ажилладаг байжээ. Ройтерс агентлагийн мэдэлснээр тэрээр, Анкара хотын Орчин үеийн урлагийн галларейд албан ажлаар бус буюу хувийн зорилгоор очсон байсан гэнэ. "HaberTur"к агентлаг Мевлют Мерт Алтынташ хэмээх энэ этгээд хэдийнэ цагдаагийн байгууллагад ажиллахаа больсон гэдгийг онцолж байна. Учир нь түүнийг долдугаар сард бүтэлгүйтсэн төрийн эргэлтийн үеэр ажлаас нь халсан байжээ. Тэрээр зургаагаас доошгүй удаа буудсан бөгөөд Алеппотой холбоотой үгнүүдийг хашгирч байсан гэдгийг дээр дурьдсан билээ. “Сабах” сонинд бичсэнээр түүнийг үзэсгэлэн рүү нэвтрэх үед металл танигч төхөөрөмжийн дохиолол дуугарч эхэлсэн ч, цагдаагийн үнэмлэхээ үзүүлэн зэвсэгтэй чигтээ нэвтэрчээ. Тэгвэл хэрэгтэй холбогдуулан Мевлют Мерт Алтынташын эцэг эх, ах дүүс нарын зургаан хүн баривчлагдсан байна.

Андрей Карлов 2013 онд Туркид суух Элчин сайдаар томилогдож байв

Анкара хотод болсон гэрэл зургийн үзэсгэлэнд оролцоходоо ОХУ-ын Элчин сайд буудуулчихна гэж санаагүй биз.

Талийгаачийн хувьд 2013 онд Туркид суух Элчин сайдаар томилогдож байжээ. Тэрээр 62 настай байсан бөгөөд 1976 оноос хойш дипломатын үүрэг гүйцэтгэж эхэлсэн байна. Мөн 2001-2006 онд Пхеньян дахь ОХУ-ын Элчин сайдаар мөн ажиллаж, үүний дараа Гадаад хэргийн яамны Консулын газрын даргаар тус тус ажиллажээ. ОХУ, Турк хоёр улс сүүлийн үед нягт харилцаатай байх болсон бөгөөд Сирийн асуудалд хоёр сөрөг хүчний эсрэг бодлого баримталж байгаа юм. 2015 онд Оросын Су-25 онгоцыг Туркийн тал буудаж унагасны дараа түүхэнд байгаагүй хэмжээнд хурцдаж байх тэр үед Андрей Карлов Анкара, Москвагийн харилцааг дахин сайжруулахад өөрийн гэсэн хувь нэмрээ оруулжээ.

Турк дахь АНУ-ын Элчин сайдын яам руу гал нээлээ

Туркид суух ОХУ-ын Элчин сайд гэмт хэрэгтний халдлагад өртөж зуурдаар таалал төгссөний дараа АНУ-ын Элчин сайдын яамыг онилсон халдлага ч мөн болжээ. Анкарад байрлах АНУ-ын Элчин сайдын яамны өмнө өчигдөр өглөө үүрээр буюу 03:50 цагийн үед буун дуу гарч, аюулгүй байдлын үүднээс тус яам түр хугацаанд хаалгаа барихад хүрсэн байна. Албаны эх сурвалжийн мэдэлснээр, Элчин сайдын яамны барилгын гол хаалганы өмнө үл таних этгээд ойртон ирж, хэд хэдэн удаа гал нээсэн хэрэг гарчээ. Гэхдээ азаар хүн гэмтэж бэртээгүй бөгөөд гал нээсэн этгээдийг саатуулсан байна. Энэ хэргээс үүдэн Истанбул, Адана дахь АНУ-ын Консулын газрууд ч гэсэн үйл ажиллагаагаа түрхугацаанд зогсоожээ. ОХУ-ын Туркид суух Элчин сайд Андрей Карлов агсны амиа алдсан гэрэл зургийн үзэсгэлэнгийн замын эсрэг талд АНУ-ын Элчин сайдын яам байрладаг байна.



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ХХК

БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ НИЙЛҮҮЛЭХ УРИЛГА

Огноо: **2016 оны 12 дугаар сарын 01**
Тендер шалгаруулалтын нэр: **Нүүрс хүчлийн хий нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **ХХ-2016/14-36**

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50 000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн баримт бичгийн төлбөрийг Голомт банкны Орхон аймгийн салбар дахь Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 400 102 2146 тоот дансанд төлсөн байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2014 он, 2015 он/
- Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил (2014 он, 2015 он)-ийн аль нэг жилд гүйцэтгэсэн нийт борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 50 000 000 төгрөг /тавин сая/ -өөс багагүй байна.
- Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн 1%-тай тэнцэх төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 цаг 50 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй. Дотоодын давуу эрх тооцно. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захиргааны II байр, 347 тоот өрөө,

Утас: 01-352-73371, 01-352-73774
Факс: 01-352-73686
Вэб сайт: www.erdenetmc.mn
E-mail: b.oyunchimeg@erdenetmc.mn



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ХХК

БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ НИЙЛҮҮЛЭХ УРИЛГА

Огноо: **2016 оны 12 дугаар сарын 01**
Тендер шалгаруулалтын нэр: **Карбид кальци нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **ХХ-2016/14-33**

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50 000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн баримт бичгийн төлбөрийг Голомт банкны Орхон аймгийн салбар дахь Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 400 102 2146 тоот дансанд төлсөн байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил /2013 он, 2014 он, 2015 он/
- Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил (2013 он, 2014 он, 2015 он)-ийн аль нэг жилд гүйцэтгэсэн нийт борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 100 000 000 төгрөг /нэг зуун сая/ -өөс багагүй байна.
- Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн 1%-тай тэнцэх төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 цаг 50 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захиргааны II байр, 347 тоот өрөө,

Утас: 01-352-73371, 01-352-73774
Факс: 01-352-73686
Вэб сайт: www.erdenetmc.mn
E-mail: b.oyunchimeg@erdenetmc.mn

ЦАГ ҮЕ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Гэрэл зургийг Т.АРГУУЖИН

Б.ДАВААХҮҮ


АШУҮИС-ийн Дотрын Анагаахын хоёрдугаар тэнхимээс тус сургуулийн дэргэдэх Сургалтын нэгдсэн эмнэлгийн Дурангийн тасгийн үйл ажиллагааг сургалчлан таниулах зорилготой нээлттэй өдөрлөгийг зохион байгууллаа. Японы OLIMPUS компаниас бэлэглэсэн тусламжын видео дурантайгаар 2004 онд анх “өрхөө татаж” байсан тус тасаг эдүгээ 12 дахь жилдээ олон улсын стандартын шаардлага хангасан сүүлийн үеийн тоног төхөөрөмжтэйгөөр, найдвартай, тухтайорчиндхоол боловсруулах эрхтний үзлэг оношлогоо, дурангийн шинжилгээ эмчилгээг чанарын өндөр төвшинд хийж байна. Мөн АШУҮИС-ийн эрдэмтэн профессор багш нар дурангийн тусламж үйлчилгээг үзүүлдэг нь ч тус тасгийн нэгэн баталгаа, нэрийн хуудас нь болдог ажээ. Сургалтын нэгдсэн эмнэлгийн Дурангийн тасгийн үйл ажиллагааг сургалчлах нээлттэй өдөрлөгийг АШУҮИС-ийн захирал, Анагаах ухааны доктор, профессор Г.Батбаатар нээж үг хэлсэн юм.

Тэрбээр “21 дүгээр зууны анагаах ухаан нотолгоонд суурилсан. Энэ утгаараа бидний оношлогоо, эмчилгээ нотлогдсон байх ёстой. Өөрөөр хэлбэл, хувь хүн өөрийн мэдрэмжээрээ, туршлагаараа эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж байсан тэртээ 1950, 60-аад оны анагаах ухаан улирч одсон байна. Тэгвэл анагаах ухааны салбарт тэрхүү нотолгоог авчрах гол хүчин зүйл нь дурангийн тусламж үйлчилгээ гэж би ойлгодог. Манай их сургуулийн Сургалтын нэгдсэн эмнэлгийн тэргүүлэх чиглэл нь ч дурангийн тусламж үйлчилгээ юм. Дурангийн тасаг 2004 онд байгуулагдсан. Тэр үед чадан ядан нэг видео дуран авчирч байсныг санаж байна. Тэр багажаа сайн ч ашигласан. Харин энэ жил нэмэлт хөрөнгө оруулалт хийж, OLIMPUS –ын дэвшилтэт технологийн дурангаар тоноглолоо. Ингэснээр эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар нэмэгдэж, бид өвчтөндөө өвдөлт мэдрүүлэлгүйгээр унтуулгатай дуран дах боломж бүрдлээ” гэдгийг онцлон тэмдэглэсэн юм. Түүнчлэн, “Бидний өнөөгийн орон зай хязгаарлагдмал хэдий ч, өөрсдийн нөхцөл боломжоо ашиглан багш нарынхаа ур чадварыг сайжруулж, оюутнуудынхаа сургалтын бааз суурийг нэмэгдүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж байна. Энэ

ажлыг нэр төртэй, зүтгэлтэй авч яваа багш наргаа нэн тэргүүнд баяр хүргэе. Бидний зовлонг бусад хүмүүс ойлгож эмнэлэг хүртэл барьж өгч байна. Тун удахгүй шинэ эмнэлгийнхээ түлхүүрийг гардаж авна. Шинэ эмнэлгийн тэргүүлэх чиглэл нь дурангийн үйлчилгээ байх болно. Шинэ эмнэлэгтээ үр дүнтэй, чанартай, хүртээмжтэй, нотолгоотой эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд өөрсдийгөө бэлтгэж, сайжруулж буйн нэг хэлбэр нь энэ. Олон хүн өвчнөөсөө салж, өвчнөө зөв оношлуулж, зовлон зүдгүүрээсээ салаасай гэж хүсч байна” гэлээ. Нээлттэй өдөрлөгийн үйл

...Дурангийн тасагт Хоол боловсруулах дээд замын дуран, Хоол боловсруулах доод замын дуран, Цөс нойр булчирхайн сувгийн дуран, Хеликобактерийн оношлогоо хийгдэхээс гадна цус тогтоох, ургацаг авах, судас боох, нарийслыг тэлэх, цөсний замын чулууг дурангаар авах, цөсний замын нарийсал тэлэх, цөс нойр булчирхайн сувгийн гуурс тавих, ходоодонд дурангаар хооллох гуурс тавих зэрэг эмчилгээ хийгдэж байна...

ажиллагаанд Японы OLIMPUS компанийн албан ёсны төлөөлөгч технологийн дэвшилгйг Монголдоо нэвтрүүлнэ уриатай “Медимпекс” компанийн гүйцэтгэх захирал Т.Отгонтуяа болон АШУҮИС-ийн багш, резедент, оюутнууд хүрэлцэн ирсэн байлаа. Нээлтийн үйл ажиллагааны үеэр Хоол боловсруулах эрхтэн судлалын тасгийн дэд профессор, АУ-ны доктор Х.Оюунцэцэг тасгийн үйл ажиллагааг ирсэн зочдод танилцуулсан юм. Тасаг өвчтөнийг бүртгэх, бэлтгэх өрөө, дуран, сэрээх өрөө, ариутгал гэсэн хэсгүүдэд хуваагдах бөгөөд орчин нөхцлөө Х.Оюунцэцэг эмч



танилцууллаа. Мөн хэрэгцээт багаж төхөөрөмж, оюутнуудын сургалтад хэрэглэгдэх материалын талаар ч хүсэлт, санал санаачилгуудыг дайж байв. Харин Г.Батбаатар захирал багш, оюутнууд, үйлчлүүлэгчдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэгдсэн багаж хэрэгслийг хэдий үнэтэй ч, боломж нөхцлөө дайчлан шийдэж өгөхөө амалж байсан юм.

Дурангийн тасагт нийт 25 мянган хүн үйлчлүүлжээ

2004 онд “OLIMPUS” компанийн тусламжийн видео дурантайгаар анх “Дурангийн оношлогоо эмчилгээ, сургалт судалгааны төв” гэх нэрээр тасаг байгуулагдаж байжээ. Харин АШУҮИС өөрсдийн хөрөнгөөр 2008 онд Японы мөн “OLIMPUS” компанийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийн “Evis EXERA” гэх дуранг худалдан авч, үйл ажиллагааг нь өргөтгөн “Дурангийн тасаг”-ийг байгуулж байсан түүхтэй.

Улмаар байгуулагдсан цагаас хойш өнөөг хүртэл нийтдээ 25 мянган хүн тус тасагт хандаж, дурангийн үйлчилгээ авчээ. Харин жилдээ 2500-3000 хүн ханддаг гэдгийг Х.Оюунцэцэг эмч дурьдаж байсан юм. Тэд хэдийнэ иргэдэд үйлчилгээгээ хүргэж, чанар, баталгаагаараа танигдсан байна. Дурангийн тасагт Хоол боловсруулах дээд замын дуран, Хоол боловсруулах доод замын дуран, Цөс нойр булчирхайн сувгийн дуран, Хеликобактерийн оношлогоо хийгдэхээс гадна цус тогтоох, ургацаг авах, судас боох, нарийслыг тэлэх, цөсний замын чулууг дурангаар авах, цөсний замын нарийсал тэлэх, цөс нойр булчирхайн сувгийн гуурс тавих, ходоодонд дурангаар хооллох гуурс тавих зэрэг эмчилгээ хийгдэж байна. Тоног төхөөрөмжийн хувьд “Evis EXERA GIF Q160” загварын видео дурангийн аппарат, Evis EX-ERA2” загварын ходоод, дээд гэдэс, бүдүүн гэдэсний иж бүрэн дурангийн аппарат зэргээр тоноглогдож дурангийн мэс ажилбар, эмчилгээ, оношлогоог чанарын өндөр төвшинд хийж байгаа юм.

Түүнчлэн, нэг ялгагдах онцлог нь халдваргүйжүүлэлтийн орчныг найдвартай хангажээ. Тодруулбал, дуранг ариутгах, хадгалах стандартын орчныг бий болгосон байх бөгөөд олон улсын стандартыг хангасан бүх төрлийн нян, вирус устгах хүчин


чадалтай Франц, Герман улсад үйлдвэрлэгдсэн дуран ариутгах бодис, ариутгагч машиныг ашигладаг байна. Ингэснээр үйлчлүүлэгчид дурангаар дамжуулан халдвар авах вий гэдгээс айх хэрэггүй гэдгийг дуулгахад таатай байна.

Дурангийн тасгаас зургаан анагаах ухааны доктор төржээ

АШУҮИС-ийн Сургалтын нэгдсэн эмнэлгийн Дурангийн тасаг өвчтөн, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхээс гадна сургалт, эрдэм шинжилгээний ажлын суурь бааз болдог байна. Тухайлбал, Мэргэжил дээшлүүлэх сургалт явагддаг бөгөөд ходоод гэдэсний дурангийн мэргэжлийн эмч нар эндээс л бэлтгэгдэн гардаг ажээ. Энэ дашрамд сонирхуулахад, Дурангийн тасагт гахай, хонины ходоод дээр туршилт явуулдаг байх юм. Жил бүр арав гаруй эмч нар энэ чиглэлээр суралцдаг байна. Түүнчлэн, оюутнуудад ч сургалтын бааз болдог ажээ. Тэд дурангийн шинжилгээ хийх, шинжилгээнд бэлтгэх, өвчтөнд эмчилгээний зөвлөгөө өгөх гэх мэт үйл ажиллагаанд дагалдан суралцдаг байна. Өөрөөр хэлбэл, Их сургуульдаа суралцаж байх хугацаандаа бодит практикт суралцсан мэдлэгийг эндээс олж авдаг байх юм. Мөн эрдэм шинжилгээ судалгааны ажлууд явагддаг гэдгийг ч тус тасгийн эмч нар онцолж байлаа. Тодруулбал, яг энэ дурангийн тасгийн сургалтын бааз дээр зургаан анагаах ухааны доктор, найман анагаах ухааны магистр эрдмийн зэрэг хамгаалжээ.

Харин өнөөдрийн байдлаар таван эмч докторын ажил, зургаан эмч магистрийн эрдмийн зэрэг горилж буй гэнэ. Түүнчлэн байгуулагдсан цагаас хойш нийтдээ 70 гаруй дурангийн эмч, 36 сувилагчийг бэлтгэн гаргажээ. Дашрамд дурьдахад, 45-аас дээш насныхан ходоодоо нэг удаа, 50-аас дээш насныхан жилдээ нэг удаа бүдүүн гэдсээ дурандуулах шаардлагатай байдаг аж. Ингэснээр ходоодны хорт хавдар, бүдүүн гэдэсний хорт хавдрыг эрт үед нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хавдрын урьтал эмгэгүүдийг эрт үед нь оношлох зэрэг давуу талтай эмч мэргэжилтнүүд анхааруулж байна. Гэхдээ удамд нь ходоод, бүдүүн гэдэсний хавдартай хүн байгаа тохиолдолд нас харгалзахгүй урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоо хийлгэх шаардлагатайг зөвлөж байв.

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА



ХРИСТИЙН СҮМ &

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

Христийн сүмд юу
өрнөдөг вэ

Нийслэлийн хэмжээнд нийт 372 сүм хийд, шашны байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас гуравны хоёр буюу 61.3 хувь нь Христ, 28.5 хувь нь Буддын шашны хийд байдаг аж. Өөрөөр хэлбэл, 228 христийн сүм, 106 буддын хийд үйл ажиллагаагаа явуулдаг байна. Тэдгээр 200 гаруй сүмийн нэгийг төлөөлөл болгож сонирхохоор “Үүрдийн гэгээ”-г зорилоо. Тус сүм 25 жилийн өмнө анх Монголд бууриа зассанаас хойш эдүгээ тарьсан үрээ улам үржүүлж, олон олон итгэгчтэй болжээ. Сүхбаатар дүүрэг, есдүгээр хороо бидний нэрлэж заншсанаар баян бүрдийн автобусны буудлаас Дөлгөөн нуур хүрэх замд гаднаа “Үүрдийн гэгээ” гэх хаягийг өлгөсөн хоёр давхар ягаан байшин бий. Гаднаас нь харахад л христийн сүм гэдэг нь хэнд ч илэрхий тус барилга нийслэлийн гэр хорооллын дунд байрлах сүмүүдийг бодвол гадаад үзэмж сайтайн зэрэгцээ нэг давхарга шүдний эмнэлэг, хэвлэлийн компани, гадаад хэлний сургалтын төв зэрэг байгууллагуудыг ажиллуулдаг юм билээ. Барилгын гаднах төмөр хашааны хаалгыг савж, дотогш орвол зүүн гар талд шүдний эмнэлэг ажиллах бөгөөд чигээрээ явмагц хоёр давхарт гарах шатны хажууд ахиаг насны хоёр хөгшин ярилцан зогсоо харагдав. “Сүм нь хаана вэ” гэж тэднээс асуувал “зүгээр шатаар гар тэнд бий” гэж эелдэг хариулан гараараа заалаа. Дээш гарвал сүмийн цуглаан аль хэдийнэ эхэлжээ. Том талбайтай танхимд хөх өнгийн бүрээстэй сандгуудыг эгнүүлэн тавьж, урд байрлах тайз дээр урдаа загалмайтай индэр байрлаж, харин түүний хажууд 30 орчим насны нэгэн залуу гитар барин микрофоны өмнө зогсон шашны дуугаа дуулж байв. Танхимын баруун урд хэсэгт цагаан ханан дээр дууны үгийг ч мөн поректороор харуулж байх бөгөөд 30 гаруй ахиаг насны хөгчүүл цугларч гараа урагш сунган хамтран дуулж байлаа. Дууны дараа уламжлалт хэв маяг бүхий цэнхэр өнгийн хантааз өмссөн пастор өнөөх индэр дээр гарч, библийн хэсгээс уншиж, үг бүрийн цаад утгыг тайлбарлах ажээ. Түүний ярианы дунд хэсэгт танхимд суугаа хүмүүс “амэн” гэх үгийг хэлж, амандаа юу хэлж буй нь үл мэдэгдэн бувтнан залбирах юм. Библийн хэсгээс эшлэн тайлбарлаж таниулах явцад



...ШШГЕГ-ын харьяа шоронгуудад очиж библийн хичээл ордог талаар дээр дурьдсан. Харин энэ долоо хоногт Чойр дахь хорих ангид очих гэнэ. Тэнд өөрсдийн сүсэг бишрэлээр өвчин зовлонгоосоо ангижирсан гэх маш олон хүн байдаг ажээ. Нэгэн итгэгч эгчийн хэлснээр амьдралдаа алдан бор дарсанд шунаж, траншенд амьдарч байсан 30 орчим насны залуу Есүс Христэд итгэн сүмд явж эхэлснээс хойш архинаасаа гарч, ухаалаг амьдралыг сонгох болжээ...

бурхныг магтсан дууг дахин дахин дуулж, мөн дундуур нь сүмийн зүгээс зохион байгуулах үйл ажиллагааны зарыг тараах ажээ. Мөн энэ үеэр “Газар тэнгэрийн бүтээгч төгс хүчит Бурхан эцэгт итгэдэг...үхсэн амьд бүхнийг шүүхээр ирэх цорын ганц хүү бидний эзэн есүс Христэд итгэдэг” гэх мэтээр элч нарын тунхагийг уншиж байв. Харин бурхнаа магтсан дууны хэсэгт цуглаанд оролцож буй бүхий л хүмүүс гараа урагш сунган алгаа тэнийлгэж буй нь анх очсон хүний нүдэнд сонин харагддаг юм билээ. Тэдний залбирлын гол сэдэв нь Монгол оронд сайн мэдээ газар сайгүй түгэн дэлгэрч, 21 аймаг, 331 сум бүрт нутгийн чуулган байгуулагдан олон монголчууд эзэн бурхан руу эргэхийн төлөө, аливаа гаж урсгалын таслан зогсоож, мөхөр сүсгээр баглаж буй бөө мөргөл, шарын шашны нөлөөлөөс монголчуудыг салгахын төлөө байх бөгөөд өвчтэй зовлонтой байгаа хэн нэгнийхээ төлөө ч залбирдаг гэж байв. Ерөнхийдөө ням гарагт эхний цуглаан 08:30 цагт эхэлдэг. Харин миний очсон нь ахмадын “Эх булаг”

гэх цуглаан байв. Ахмадын цуглаанд 100 гаруй хүн оролцдог гэнэ. “Үүрдийн гэгээ” сүмийн итгэгчид харьцангуй олон тул ийнхүү ахмадын, залуучуудын, өсвөр-оюутны, хүүхдийн гэх дөрвөн ангилалд хуваагддаг аж. Ахмадын цуглаан 12:00 цагт үндсэндээ дуусч, түүний дараа 13:00 цагаас залуучуудын цуглаан эхэлдэг байна. Сүүлийн жилүүдэд тус сүмд явах итгэгчдийн тоо улам нэмэгдэж, нас нь ч улам залуужсан аж. Хүүхэд байхаасаа сүмд явсан залуус хоорондоо гэрлэж, эдүгээ үр хүүхэдтэйгээ хамт ирж, залбирч мөргөдөг гэнэ.

Шинэ хүн угтах
ажиллагаа

Цуглаанд ирсэн 30 гаруй хүмүүс дундаас ялгарахгүйг хичээж, хамгийн арын суудал бараадсан намайг шинэ хүн гэдгийг бүгд л мэдсэн байв. Пастор библийн хэсгээс уншиж танилцуулсныхаа дараа тайзны хэсэгт байрлах хайрцагт өргөл өргөхийг итгэгчдээсээ хүслээ. Тэнд цугларсан хүн бүр л суудлаасаа

босч, хайрцагт хандив өргөх бөгөөд хандиваа хийдэг дугтуй нь тусдаа байдаг бололтой. Бүгд л ижил өнгийн дугтуй мэт зүйлийг гартаа атгасан байв. Харин үүний дараа өнөөдөр шинээр ирсэн хүн байвал суудлаасаа босно уу хэмээн урихад нь би ч босч орхилоо. Тэнд цугларсан бүх хүний харц зөвхөн шинээр ирэгчид тусч, хэр барагийн монгол хүнд баймгүй найрсаг зангаар угтах нь тэр. Тайзан дээр дуу дуулж байсан гитартай залуу ч шинээр ирж буй хүнд зориулан бурхнаа магтсан дуугаа дуулж өгөхөд цугларсан хүмүүс бүгд л гараа над руу чиглүүлж, зарим нь биед гараа хүргэн амандаа учир нь ойлгогдож үл сонсогдох үгсийг бувтнан хэлж байлаа. Дуу дууссаны дараа цуглааны найрсаг ахиаг насны эгч нар дэргэд ирж тэврэн үнсэх бөгөөд бурхны хайраар тэвэрч байна хэмээн түүнийгээ тайлбарлаж байсан нь тун ч сонин санагдаж байсныг нуух юун. Тэд ийн шинэ хүнээ угтаж авдаг аж. Христэд итгэгчид нас хүйс, хөрөнгө мөнгө, зүс царай, боловсрол үл харгалзан тэднийг зорин ирсэн бүхнийг ингэж угтдаг бололтой. Харин дараа нь тус сумын уламжлалт үйл ажиллагаанд хандив өргөхийг мөн уриалж байв. “Үүрдийн гэгээ” сүмийн итгэгчид ШШГЕГ-ын харьяа чанга дэглэмтэй болон жирийн дэглэмтэй хорих ангиудад очиж, ялтангуудад библийн сургалт зохион байгуулдаг гэнэ. Уламжлалт энэ үйл ажиллагаанд гарах зардлыг ч итгэгчид хандивладаг ажээ. Гэхдээ тогтсон ханш гэж байхгүй. Тухайн хүн боломжоороо, хүнд хэдий хэрийн мөнгийг хандивлахыг хүснэ төдий хэмжээний мөнгийг л өгдөг юм байна. Тэнд ирсэн хүмүүсийн ихэнх нь энэ үйл ажиллагаанд 1000 төгрөг, арай боломжтой зарим нь 5000-ыг өгч байв. Ингэхдээ өгөөгүй хүн ч байх авч, өгөхийг шахсангүй.

“Үүрдийн гэгээ”
сүмийнхэн
хүмүүжигчдэд библийн
сургалт зохион
байгуулдаг гэнэ

Цуглаан 12:00 цагт өндөрлөж, үүний дараа нөхөрлөлийн цаг эхэллээ. Цуглааны танхимд сэрүүхэн байх бөгөөд нимгэн хувцастай бол даарч мэдэхээр байв. Харин “Нөхөрлөлийн цаг”-аар итгэгчид доош бууж, лудволын давхарт байрлах гал тогооны хэсэгт очин өдрийн хоол иддэг юм билээ. Тэндээ ширээнүүдэд хуваагдан сууж, өнгөрсөн долоо хоногт өөртөө тохиолдсон, мэдсэн, сурсан бүхнээ ярьж зөвлөлдөхийн

сацуу ирэх долоо хоногт хийх ажлаа ч төлөвлөдөг ажээ. Сүмийн үдийн хоол гоймонтой хуурга байв. Сүмийн зүгтээс сардаа 30 мянган төгрөг өгөх бөгөөд түүн дээр хэсгийн итгэгчид хандив өргөж, ням гарагийн өдөр бүр Нөхөрлөлийн цагаар хамтдаа хооллоцгоодог байна. Тус сүмийнхэн ШШГЕГ-ын харьяа шоронгуудад очиж библийн хичээл ордог талаар дээр дурьдсан. Харин энэ долоо хоногт Чойр дахь хорих ангид очих гэнэ. Тэнд өөрсдийн сүсэг бишрэлээр өвчин зовлонгоосоо ангижирсан гэх маш олон хүн байдаг ажээ. Нэгэн итгэгч эгчийн хэлснээр амьдралдаа алдан бор дарсанд шунаж, траншейнд амьдарч байсан 30 орчим насны залуу Есүс Христэд итгэн сүмд явж эхэлснээс хойш архинаасаа гарч, ухаалаг амьдралыг сонгох болжээ. Амьдралдаа өөрчлөлт хийсэн тэрхүү эрийг гаднаас харахад хэн ч архичин байсан гэж хэлэхээргүй цэвэрхэн залуу байв. Хажуугаар нь өнгөрөх эгч нар түүнийг улам л сайхан болж байна шүү гэж урамшуулж байгаа нь харагдсан. Харин 40 нэлээд гарсан болов уу гэмээр малгайтай ногоон цамц өмссөн хөдөлгөөнтэй нэгэн эмэгтэй гурван жилийн өмнө өвчний улмаас бие нь мэдрэлгүй болж, аягатай цайгаа ч барьж чаддаггүй байсан гэнэ. Харин Христэд итгэснээр өөрийн сүсэг бишрэлээр эдүгээ ямартай ч, аяга цай, идэх хоолоо өөрөө идэж, цуглаандаа хүртэл явдаг болсон аж. Надад энэ бүхнийг хуучлах эгч сүмд яваад 10 гаруй жил болжээ. Тэр ч мөн адил бамбай булчирхайн хорт хавдартай гэж оношлогдон эмчилгээгүй, хэдхэн сарын настай гэгдэж явсан ч, бурханд итгэснийхээ ачаар эдгэрсэн гэв. Шинээр ирж буй хүнийг өөрсдийн цуглаандаа элсүүлэх нэг хэлбэр нь энэ ч байж мэдэх. Мөн англи хэл, компьютерийн сургалтад ч гэсэн итгэгчдийгээ суралцуулдаг аж. Үүрдийн гэгээ сүмийн хувьд энэ мэт ажлыг хийдэг бололтой. Харин нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг бусад сүмийн зарим пасторууд нь хувийн байраа оюутнуудад хямд үнээр түрээсэлж, өсвөр насныхныг сургуульд суралцахад нь тусалцаа үзүүлэхээс гадна хандив цуглуулан ядуу зүдүү амьдралтай иргэдэд тусалдаг гэнэ билээ. Христийн шашны шугамаар манайд маш олон хандив, тусламж орж ирж, маш олон төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа. Христийн сүмийнхэн оронгэргүй иргэдэд хоол унд, хувцас хунар өгдөг аж. “Дэлхийн зөн” олон улсын байгууллага гэхэд Христийнх.

Энэ байгууллагын шугамаар ямар их тусламж явдаг билээ. Дезерент гэх олон улсын энэрлийн байгууллага л гэхэд Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмээс санхүүждэг гэсэн. Тус байгууллага Нийслэлийн цагдаагийн газрын дэргэдэх Хүүхдийн халамж үйлчилгээний төвд хандив өргөж байсан удаатай. Түүнчлэн, 2010 онд Онцгой байдлын газар, зудад нэрвэгдсэн аймгуудын засаг дарга нартай хамтран ажиллаж гамшигт нэрвэгдсэн малчин өрхүүдэд 280 сая төгрөгний хандив өргөж байлаа. Энэ нь ч магадгүй христийн шашинтнууд улам нэмэгдэх суурь болдог ч байж болох. Тэгвэл буддын хийдэд юу өрнөдөг талаар сонирхож үзье.

Буддын хийдэд юу
өрнөдөг вэ

“Үүрдийн гэгээ” сүмтэй ойролцоо буюу бидний нэрлэж заншсанаар Ардын эрхийн автобусны буудлын орчимд “Дашчойлин” хийд байрладаг. Тус хийдийн хаалгаар ормогц хашаанд гурван хийд байх бөгөөд урд хэсэгт хоёр хийдийн барилга зэрэгцэн байрлаж байлаа. Баруун гар талын хийдийн урд хаалгаар орвол банкны төлбөрийг санагдуулам шилэн цонхны цаана 3-4 хүн сууж буй харагдав. Хөх өнгийн юпка, хантаазыг цагаан цамцтай хослуулан өмссөн тэд үнэндээ яг л банкны ажилтан мэт харагдаж байсныг нуух юун. Шилэн цонхны өмнө охинтойгоо яваа нэгэн настай эмэгтэй зогсох бөгөөд зурхайчийн уншуул гэсэн номын нэрсийг гартаа барьж, ажилтнуудад нь бичүүлж зогсох ажээ. Харин танхимын баруун болон зүүн хэсэгт хийдэд байнга уншдаг номын нэрсийг бичсэн байх бөгөөд ард нь ямар утга агуулгатай болохыг нь тайлбарлан бичсэн байлаа. “Дашчойлин” хийдийн хувьд тогтсон тарифгүй. Хувь хүмүүс номоо бичүүлснийхээ дараа өөрсдийн өргөлөөр мөнгө өгдөг гэнэ. Нэг хүнд унших номын нэрсийг бүгдийг бичүүлснийхээ дараа өргөл өгч, энэ мэтээр дөрвөн ам бүлтэй айл байлаа гэхэд 10 орчим мянган төгрөгийн өглөгөөр ном хуруулдаг байна. Өнөөдөр бичүүлсэн номыг хийдийн лам нар маргааш нь уншдаг учир сүсэгтэн олон ч, номоо бичүүлээд л гэртээ харьцдаг бололтой. Тэндээс гарч хийдийн баруун талын хаалгаар орвол асар том эрхийг тойруулан тавьсан байх авч, хэн ч байсангүй. Угтаа энд зурхайчид сууж, сүсэгтэн олны жилийн засал, ямар ном уншуулахыг нь хэлж өгдөг байна. Зурхайчид ч гэсэн тодорхой тарифгүй тул тухайн хүний өгсөн мөнгийг л авдаг аж. Харин хажуугийн дуганд орвол лам нам ном уншиж байв. Дуганы баруун талд 20 орчим хүн алгаа хавсран сууж байгаа харагдлаа. Лам нарын ажил ерөнхийдөө 09:00 цагт эхэлдэг байна.

Шашны сургуулийн
төлбөр гурван сая
төгрөг

Христийн сүмийн хувьд цуглаанд олон жил явж, сургалтад суралцсан, мөн дээр нь идэвхи зүтгэлтэй нэгнийг пастор болгодог байна. Өөрөөр хэлбэл, анх христийн шашны үрийг Монголд гадаад

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

БУДДЫН ХИЙД



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

хүмүүс тарьж байсан бол эдүгээ ихэнх сүм хийд монгол пастортой болжээ. Тэд сүмдээ цуглаан зохион байгуулж итгэгчдийнхээ тоог нэмэхэд туйлын их анхаардаг бол Буддын шашны хийдүүдийн хувьд тухайн шашныг сүсэглэн бишрэх иргэдийн тоог нэмэгдүүлэхэд төдийлөн анхаарал тавьдаггүй. Харин гагцхүү хойч үеэ, лам нараа бэлтгэхэд л анхаардаг аж. Нэг талаар уламжлалт шашин гэх тодотгол нь л буддын шашныг эдүгээг хүртэл оршсоор байхад нөлөөлсөн бололтой. Манай улсын хэмжээнд буддын хэд хэдэн дунд сургууль, коллеж, их сургууль байдаг . Энэтхэг рүү явж суралцах хүүхдүүд ч олон байдаг бөгөөд тэдний хувьд 16 жил суралцдаг гэдгийг нэгэн лам бидэнд хуучиллаа. Харин дотооддоо сурах бол Гандантэгчинлэн хийдийн Их сургуульд жилийн гурван сая төгрөгийн өртгөөр сурах боломжтой аж. Мөн аль нэг сургуульд суралцахгүйгээр хийддээ шавилж, ном судраа цээжлээд явах боломж нь ч тухайн ламын хувьд нээлттэй байдаг гэнэ. Нэг ёсондоо лам болно гэдэг насан туршийн амьдралын баталгаа болох мэргэжлээ эзэмшиж буйгаас ялгаагүй учир төлбөр нь ч гэсэн бусад мэргэжил олгох их, дээд сургуулийн төлбөртэй ижил байдаг бололтой.

Гандантэгчилэн, Мамба дацан хийдүүд унших номондоо тариф тогтоодог

Гандантэгчилэн, мамба дацан хийдийг зорив. Сүүлийн өдрүүдэд цаг агаар хүйтэрсэн ч сүсэгтэн олны хөлд хийд дарагджээ. Жанрайсаг бурхандаа мөргөж, хүрд эргүүлж, хүслийн модонд хүслээ шивнэж, арцаар арвилах, мөн зүгээр л зураг авахуулахаар ирсэн иргэд ч тэнд байгаа харагдсан. Гандантэгчилэн хийдийн хувьд засал номондоо тариф тогтоосон байдаг бөгөөд

...“Суврага шүтээн босгох нь буян боловч, хүүхдийн эмнэлэг барих нь цаглашгүй буян болай” гэж бурханы сургаалийн үнэт ухагдахууныг энгийнээр тайлбарласан байдаг. Үүнээс л буддын сургаалийн үнэн мөн чанар болон Монголын бурхан шашинтнуудын үйл хэргийн ялгаа харагдана...

харьяа дацангуудад тодорхой тарифүйлчилдэг. Дацанбүрийн үүдэнд үнийн тариф өлгөөстэй байх аж. Сүсэгтнүүд тус үнийн тарифийг харж, мөнгөө тушаан номоо бичүүлдэг. Тарифийн хувьд Алтанганжуур гэх мэт томоохон номуудын үнэ 10 мянга, дүнсэр заслыг 3000, гүймэг заслыг 5000, суудал өнцгийн заслыг 500 төгрөгөөр хийдэг. Харин Мамба Дацан хийдийн хувьд уншуулах номоо хэлмэгц л тогтсон үнэ ханшийг нь танилцуулна. Сүсэгтэн олон ихэвчлэн “Сэдномын догжир” нь хэл амьг зайлуулах, “Чойжоо дүгжүү” нь муу зүйлийг зайлуулах, “Цэвэгмидийн чого” нь насны ном зэргийг ихээр айлтгуулдаг байна. Эдгээр ном нь үнэ 10-20 мянган төгрөг. Харин бусад заслын ном буюу хийморийн сан тавиулах зэрэг нь 1500-5000 төгрөгийн үнэтэй гэнэ. Хийд дээрээ өглөө, өдрийн

цагаар ном хурсан лам нар орой болоход айлд залагдаж, засал номыг нь айлтгадаг. Лам нарын хувьд тодорхой тариф байхгүй ч, сүсэгтэн олны хувьд хэдий хэмжээний их мөнгө өгнө, төдий хэрээр буян нь арвижна гэх бичигдээгүй хууль үйлчилдэг учраас тэр бүр бага мөнгө өгдөггүй билээ. Хамгийн гол нь Христийн сүмүүд цуглаан ирсэн итгэгчдээсээ хандив авч түүнийгээ нийгмийн эмзэг давхаргын ядуу зүдүү хүмүүст туслахад зориулдаг бол энэ мэтээр “тусгай тариф”-тай ном айлдаж, түрүүвчээ түнтийлгэж буй хийдийнхэн хэр барагтай л бол буяны үйлсэд гар сунгадаггүй нь хачирхалтай. Магадгүй өдөр бүр уншиж буй номоо ард түмний сайн сайхны төлөө буян үйлдэж байна гэж боддог ч байж мэдэх юм.

“Өөрт нь өргөл өргүүт л аварчихдаг бурхан авлигач түшмэлээс ялгаагүй”

“Өөрт нь өргөл өргүүт л аварчихдаг бурхан авлигач түшмэлээс ямар ч ялгаагүй” хэмээн “Жавзандамба Хутагт төв”-ийн багш Д.Нямсамбуу саяхан өгсөн ярилцлагадаа дурьдсан байв. Тэгвэл тухайн хүний сайн сайхны төлөө ном хурж буй хийдийнхэн засал номдоо тариф тогтоосон нь шашны мөн чанарт нийцэх болов уу. Түүнчлэн, хийдийн лам нар нийгмийн эмзэг давхаргынханд тусаллаа гэх мэдээлэл ч хэвлэлийн хуудаст тэр бүр гараад байдаггүй. Үнэн хэрэгтээ гэр хорооллын өнцөг буран бүр дэх өнгөтэй өөдтэй барилгууд бүгд л христийнх байна гэх шүүмжлэлийг хэдэнтээ сонсч байв. Гэхдээ сүсэгтэн олноосоо хандив цуглуулж, унших номоо тарифжуулж, завтай цагтаа “халтуур хийх” лам нар чөлөө завгүй ажиллаж, өдрийн хоногоо арайхийн болгож буй жирийн иргэдээс ч баян шүү. Шашны сургааль хэрхэн гажууддагийн



сонгодог жишээг зурхайч лам нар үзүүлнэ. Сар шинийн баяр дөхмөгц л хэдэн хэсэг талцаад маргалдаж гарна. Аль нь ч зөв аль нь бурууг хэн ч эс мэднэ. Өнөөхөөрөө далимдуулаад тус бүрнээ цаг тооны бичиг гаргаад л ашиг орлогыг ёстой хүүлж өгнө. Үнэхээр энэ чинь үнэнд хүрэх бурхан Буддагийн номлол мөн гэж үү. Христчүүд өнчин ядуусыг өргөж тэтгэж, өглөг хандив өргөж байхад буддын лам нар эсрэгээр нь сүсэгтэн олноос өргөл хандив дээр “дээрэм” хийж суух. Аймаг болгон бурхан багшийн дүр, өч төчнөөн суваргыг хэдэн тэрбум төгрөгийн санхүүжилтээр босгож байна. Ядахнаа цөөхөн ч гэсэн айл өрхийг гэр суцтай, ажил төрөлтэй болгосон бол бусдыг энэрэхүйн бурхны сургаальд нийцэхсэн. Гэхдээ аливаа зүйл хоёр талтайг мартаж болохгүй.

“Жавзандамба Хутагт” төв 40 айлд хувцас тараажээ

Томоохон хийдүүд өнчин, ядуусыг өргөж тэтгэхээ мартаж, харин ч шинээр барих Гандан хийддээ татвар төлөгчдийн мөнгөнөөс татаж, улсын төсөвт суулгуулж байсан жишээ саяхных. Гэхдээ буддын шашны байгууллага бүр ийм гэвэл эндүүрэл болно. Эндганцханжишээгдурьдахыг хүслээ. Учир нь хэвлэлээс хайж хайж олсон ганц жишээ энэ байсан юм. Тодруулбал, “Жавзандамба Хутагт” төв буддизмыг мэдье, ойлгоё гэсэн хүмүүст зориулсан тогтмол сургалтыг сүүлийн зургаан жил явуулжээ. Энэ сургалтын төвийн зорилго нь нэгдүгээрт Буддизмын талаар үнэн зөв ойлголт өгөх, хоёрдугаарт Буддизмд

суурилсан ёс суртахуун, итгэл үнэмшлийг хүмүүст хүргэх юм байна. Мөн хоёр сар тутамд тогтмол хүмүүнлэгийн ажил хийдэг аж. Саяхан гэхэд Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хороонд 60-70 хайрцаг хувцас, хоол унд, бэлэг сэлт, мөнгөн тусламж зэргийг 40 орчим айлд тараажээ. Тус төвийн сургалтад хамрагдсан хүмүүсийн өргөсөн хандиваар ийнхүү хүмүүнлэгийн ажил хийсэн гэнэ. Мөн Хорт хавдар судлалын үндэсний төв дээр долоо хоногийн дөрвөн өдөр төвийн лам нар очиж сэтгэл асрах үйлчилгээ үзүүлдэг аж.

Монгол буддын шашинт орон мөн үү

Цусны хорт хавдартай хүүхдийн эмчилгээний төвийг бариулсан Ажиа гэгээнтэн “Суврага шүтээн босгох нь буян боловч, хүүхдийн эмнэлэг барих нь цаглашгүй буян болай” гэж бурханы сургаалийн үнэт ухагдахууныг энгийнээр тайлбарласан байдаг. Үүнээс л буддын сургаалийн үнэн мөн чанар болон Монголын бурхан шашинтнуудын үйл хэргийн ялгаа харагдана. Манай бурханы шашинтнуудын дийлэнхи нь бурханд өөрийгөө даатгаж ажил, амьдрал, эрүүл мэндээ сайн сайхан байлгахын төлөө ном хуруулдаг. Лам хуврагууд нь арга засал, тарни уншин үйлчилгээ үзүүлж, “төлбөрөө авна”. Гэтэл манайхаас өөр бурханы шашин хөгжиж байгаа оронд буддист хүн ерөөсөө амьдралынхаа зан үйлээр үргэлж сайн сайхныг сэтгэлдээ тээж, бусдад буян тус хүргэхийг хичээх болжээ. Бүтэн жилийн турш хилэнцдэг сэтгэлтэй явсаар сар шинэ гармагц учиргүй ном хуруулж, алга хавсран залбирах нь өөрөө өөрийнхөө нүглийг л аргалуулах гэсэн авлига. Харин уншиж хурах номоо цайны газрын хоолны цэс шиг үнэлгээжүүлсэн Монголын хийдүүд олон жилийн турш сүсэгтэн оlnыхоо өглөгийг хангалттай хүртлээ. Одоо хишиг буянаа хайрлах болоогүй юу.

Тал нутгийн цахим мэдээлэл

NO STRESS

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -15
Шөнө -22

Нөгөөдөр
Өдөр -14
Шөнө -24

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДУНД
ЦАГААН ХУЛГАНА САР
ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ
УЛААГЧИН ҮХЭР ӨДӨР

Наран ургах шингэх: 08.39-17.02
Үс засуулбал: Эд эдтэл идээ ундаа



Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг туу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр андгай тангарагаас няцах, дайсныг нотлуулах үйлд сайн. /туу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/ хууцас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Эл өдөр зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олдох, зүүн чих хангинавал айлшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болох болой. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой.

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улс уг нь өвөл болдог цөөн орнуудын нэг гэж байгаа. Дэлхийн хамгийн хүйтэн нийслэлтэй улс ч гэдэг. Ер нь бол цас мөсний орон л доо. Манайд өвөлтэй холбоотой бүх л сайхан, муухай зүлс бий. Тухайлбал, утаанаас авахуулаад Харин нэг л зүйл алга байгаа нь өвлийн спорт. Дэлхий дахинд өвлийн спорт дээд цэгтээ хүртэл хөгжөөд, олон янзын тэмцээн уралдаан зохион байгуулдаг болчихлоо. Бүр Олимпын наадам хүртэл байгаа юм билээ шүү дээ, нөхөд минь. Гэтэл манайд бараг хамаагүй юм шиг л байна. Өнгөрсөн өвлийн Олимпын наадамд цанын хоёр тамирчин оролцсон байх. Харин тэшүүрийн тамирчин Б.Сумъяа Залуучуудын өвлийн олимпын наадамд түрүүлж байж энэ спортыг жаахан мэдрүүлсэн байх, хүмүүст. Гэхдээ одоо эргээд мартчихсан байна. Ер нь сүүлийн хэдэн жил арай л жаахан идэвхтэй ажиллаж, тамирчдаа бэлтгэж байгаа нь тэшүүрийнхэн. Гэвч Тэшүүрийн холбоо гэж лойчихсон газар, төр засаг нь гэж нүдэн балай, чих нь дүлий. Ингээд л тэшүүрчдийн хөдөлмөр талаар болж байна. Уг нь тэшүүрчид дараагийн өвлийн олимпын наадмын эрхийг авчих санаатай үзээд байгаа юм. Харамсалтай

нь дэмжиж байгаа хүн алга. Тэшүүр, цана, чаргаа ялгадаг дарга ч байдаг юм уу, үгүй ч юм уу, бүү мэд. Биеийн тамир, спортын газрын даргаар нэг сайхан өндөр, цагтаа сагсан бөмбөг тоглож явсан Ц.Шаравжамц гэдэг залуу ажиллаж байгаа. Мань эр Спортын төв ордныг шинэчлэнэ гээд овоо хэдэн сая ам.долларын хөрөнгө оруулалт энэ тэр яриад байгаа. Түүний ярьж байгаа бүтвэл Спортын төв ордон гээч чинь сүртэй газар болох юм биш үү. Спорт, энтэртайментийг цогцлоосон, тамирчдыг бэлтгэл сургуулалт хийх нөхцлөөр хангасан дэлхийн жишигт нийцсэн ордон босгоно гээд байгаа. Яахав, сайхан л хэрэг. Харин мань эр өвлийн спорт гэж байдгийг бас л мартчихлаа. Ер нь ч үе үеийн дарга, албан тушаалтнууд өвлийн спорт гэж байдгийг мэддэггүй, эсвэл мартчихаад байдаг муу талтай. Тэр жишгээр Ц.Шаравжамц даргатай явж байгаа бололтой. Аргагүй л дээ хөөрхий, ширэн бөмбөг л хөөж явсан болохоос чана, тэшүүр гэж юугаа л мэдээ аж. Хоккей, уран гулгалт, шорт трейк сонирхдоггүй бол яаж өвлийн спортын талаар санах юм. Харин ч спортын төв ордныг сагсны ордон болгоно гээгүй нь их юм. Тийм болохоор нэг газрын даргатай ярих асуудал ч биш байх. Тэгсэн дор бол Монгол Улсын Засгийн газрын гишүүд, Ерөнхий сайдад өвлийн спорт гэдгийг маш сайн, нарийн тайлбарлаад, хэдэн цагийн сургалт хийж, жаахан ойлголт өгчихөөд, дараа нь гуйвал дээр болов уу.

Өвлийн спортынхон, тэр дундаа мөсөн дээгүүр гулгадаг нөхдүүд нэгдэж аваад, төр засгийнханд жаахан сургалт хийчихээч. Манайд өвөл болдог, тийм болохоор цана, тэшүүрээр гулгаж болно. Тэр нь спортын төвшинд хүрчихсэн гэдгийг хэлээд өгөх хэрэгтэй. Тэгэхгүй болохоор хотын замын цасыг арилгахгүй болохоор гулгаа үүсээд, машин явж болохгүй гулсаад байгаа л өвлийн спортын хавьд хамаатуулж ойлгоод байгаа шүү дээ хөөрхийс. Мөн төв талбайд нэг хашаа маягийн юм бариад, үс асгаж хөлдөөгөөд, хүүхдүүд гулуульж тоглуулж байгаагаар төсөөлдөг ч байж болно. Гэтэл спорт арай өөр. Ядаж л өвлийн спортын битүү ордонтой болчихвол тэшүүр, уран гулгалт, шорт

трейк, хоккей гээд маш олон спорт хөгжиж болохоор байгааг ойлгохгүй байна. Түүнийг зааж өгөөч ээ хөөрхийст. Тэгээд сайтар ойлгочих юм бол нэг өдөр бодож сууж байгаад гэнэт шийдээд, өчнөөн жил ярьсан өвлийн спортоо ордноо барих газар ч болов шийдээд өгчих ч юм бил үү, хэн мэдтээ. Тэгвэл тэшүүрийнхэн минь холбооныхоо удирдлага гэсэн унхай нь урагдчихсан юмнуудыг харж, бухимдаж суухгүй амар л болно доо.

...Манайд өвөл болдог, тийм болохоор цана, тэшүүрээр гулгаж болно. Тэр нь спортын төвшинд хүрчихсэн гэдгийг хэлээд өгөх хэрэгтэй. Тэгэхгүй болохоор хотын замын цасыг арилгахгүй болохоор гулгаа үүсээд, машин явж болохгүй гулсаад байгаа л өвлийн спортын хавьд хамаатуулж ойлгоод байгаа шүү дээ хөөрхийс...

ДУУЛГАХ СОНИН

Харшийн сүлд модны наадам ЭНЭ САРЫН 28-НД БОЛНО

Монголын Хүүхдийн ордон 1958 онд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж, төрөл бүрийн урлаг спорт олон нийтийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцуулах зорилгоор анх байгуулагдсан түүхтэй. Түүнчлэн, мөн оноос эхлэн Харшийн сүлд модны наадмыг зохион байгуулж эхэлсэн байдаг. Шинэ оны босгон дээр болдог уг наадмаар хүүхэд бүхэн ид шидийн ертөнцөөр аялж, тэр жилийнхээ амжилт бүтээлээ тайлагнан, өвгөн аавынхаа

хишиг буяны дээж болох уут дүүрэн амттай бэлгийг гардан авдаг байв. Гэвч сүүлийн жилүүдэд нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалж, үлгэрийн мэт Харшийн сүлд модны наадам тасалдахад хүрсэн нь нууц биш.

Тэгвэл Монголын Хүүхдийн ордон энэ уламжлалаа сэргээж, албан ёсны оюуны өмчийн эрхтэйгээр энэ жилээс эхлэн Харшийн сүлд модны наадмыг жинхэнэ утгаар нь зохион байгуулж, хүүхэд багачууддаа бэлэг барихаар болсон байна. Шинэ жилийн аливаа баярыг

өвлийн өвгөн аавгүйгээр төсөөлөхөд бэрх. Тэгвэл энэ наадамд 47 жилийн турш тасралтгүй өвлийн өвгөний дүрд тоглосон Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт Ардын жүжигчин Г.Гомбосүрэн эдүгээ ч ард олондоо тэр л дүрээрээ дурсагдсаар ирсэн байдаг бол 2005 оноос МУ-ын гавьяат жүжигчин Хасар Жагаа буюу Б.Жаргалсайхан өвлийн өвгөний дүрээр жил бүрийн арванхоёрдугаар сард хүүхэд багачуудтайгаа учран золгодог болсон юм. Харин албан ёсны оюуны өмчийн эрхтэй

Харшийн сүлд модны наадам энэ сарын 28-наас эхлэх бөгөөд Хүүхдийн ордоны авьяаслаг хүүхдүүдийн урлагийн тоглолт, уут дүүрэн бэлэг, олон олон гэнэтийн бэлэг хүлээж буй гэнэ. Энэ үеэр Нийслэлийн боловсролын газартай хамтран шилдэг хүүхэд, онц сурлагатан хүүхдийг өргөмжлөх юм байна. Гэхдээ зөвхөн онц сурлагатанууд гэхгүйгээр нийслэлийн бүхий л сургуулийн сурагч, хүүхдүүд тус наадмыг очиж үзэх боломжтой. Тасалбар ердөө 29000 төгрөг аж.

“SNOW MELODY”-Г баасан гарагт тоглоно



Дэлхийн улс орны ард түмний шашин шүтлэг, яс үндэс, гарал угсаа ул хамаарч улс хоорондын эв нэгдэл тэр дундаа гэр бүл, хүүхэд залуучуудын баяр лан өнгөрүүлдэг баярын нэг бол шинэ жилийн баяр юм. Шинэ жилийн баярыг гэр бүл, анд нөхөд, хайртай дотны хүмүүстэйгээ хамт

байж зугаатай өнгөрүүлдэг баяруудын нэг билээ. Энэ шинэ жилийн баяраар улсын Филармони уламжлал болгон хүргэдэг “SNOW MELODY” new year’s concert-2017 тоглолтоо баасан гарагт СТӨ-ний тайзнаа ганцхан удаа тоглох гэж байна. Тоглолтод улсын Филармонийн Симфони найрал хөгжим, Баянмонгол жазз найрал хөгжим, Морин хуурын чуулга, Филармонийн гоцлол дуучид, МУАЖ Б.Зангад, поп хатагтай МУГЖ Б.Сарантуяа зэрэг 200-аад уран бүтээлчид оролцох юм байна.

ХӨЛБӨМБӨГ

“Наполи” Мөртенсийн гэрээг сунгахаар төлөвлөж байна

Италийн “Наполи” клуб багийнхаа довтлогч Дрис Мертенсын гэрээг сунгахаар төлөвлөж байгаа ажээ. Бельгийн шигшээ багийн довтлогчийн “Наполи”-тай байгуулсан гэрээ 2017 оны хоёрдугаар сард дуусах бөгөөд багийн удирдлагууд түүнээс өмнө гэрээг нь сунгахаар яаравчилж байна. Тэгэхдээ 2021 он хүртэл гэрээгээ сунгахаар төлөвлөжээ. Мертенс “Наполи”-гийн төлөө сүүлийн хоёр тоглолтод долоон гоол оруулчихаад байгаа билээ. Тэр дундаа Италийн Сери А лигийн 17 дугаар тойрогт покер хийгээд амжсан юм.



АЛБАН БАЙГУУЛЛАГЫН ЦЭВЭРЛЭГЭЭ

- Их цэвэрлэгээ
- Гэрээт цэвэрлэгээ
- Гадна фрасадны цэвэрлэгээ
- Гадна талбайн цэвэрлэгээ
- Барилгын болон засварын дараах цэвэрлэгээ
- Үлдэцгүй нүлээн авалтын дараах цэвэрлэгээ

SODON

cleaning service

БҮХ ТӨРЛИЙН ЦОГЦ ЦЭВЭРЛЭГЭЭ

АЙЛ ӨРХИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ

- Их цэвэрлэгээ
- Энгийн цэвэрлэгээ
- Хэсэгчилсэн цэвэрлэгээ
- Цонх тогтны цэвэрлэгээ
- Цонх тогтны засвар үйлчилгээ
- Хивс, хивсэнцэр цэвэрлэгээ

УТАС: 95018180, 88120500, 99003618

FACEBOOK: SODON SERVICE